



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



Монгол Улсын
Хүний Эрхийн
Үндэсний Комисс



**Монгол Улс дахь заавал хаах
цэргийн алба ба хугацаат
цэргийн хөдөлмөр:**

**Бодлого, практикийн дүн
шинжилгээ**




Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



Монгол Улсын
Хүний Эрхийн
Үндэсний Комисс

Монгол Улс дахь заавал хаах
цэргийн алба ба хугацаат цэргийн
хөдөлмөр:

Бодлого, практикийн дүн шинжилгээ



УИН.МН
СУДАЛГААНЫ САН

Copyright © Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага 2016

2016 онд анх удаа хэвлэгдэв.

Олон улсын хөдөлмөрийн товчооны хэвлэл нийтлэл нь Зохиогчийн эрхийн тухай түгээмэл конвенцийн 2 дугаар Протоколд заасны дагуу зохиогчийн эрх эдэлнэ. Гэвч эх сурвалжийг нь дурдсан тохиолдолд зөвшөөрөл авалгүйгээр тэдгээрээс иш татан ашиглаж болно. Дахин хэвлэх буюу орчуулах эрхийг авахын тулд ОУХТ-ны Хэвлэл нийтлэлийн албанд (Эрх, зөвшөөрөл) ILO Publications, International Labour Office, CH-1211 Geneva 22, Switzerland гэсэн хаягаар, эсвэл rights@ilo.org гэсэн цахим шуудангаар хандана уу.

Хуулбарлах эрхийн байгууллагуудад бүртгэлтэй номын сан, байгууллага болон бусад хэрэглэгчид тэдэнд олгогдсон зөвшөөрлийн дагуу номыг олшруулж болно. Танай улсад буй хуулбарлах эрхийн байгууллагын талаар www.ifrro.org хаягаар мэдээлэл авна уу.

Монгол Улс дахь заавал хаах цэргийн алба ба хугацаат цэргийн хөдөлмөр: Бодлого, практикийн дүн шинжилгээ / Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс: ОУХБ, ХЭҮК 2016

ISBN 9789220307519 (print); 9789220307526 (web pdf)

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

цэргийн алба /албадан хөдөлмөр / хууль зүйн тал / зөвлөмж / Монгол Улс

13.01.2

Англи, Монгол хэлээр

ОУХБ-ын хэвлэлийн каталоги

Нэгдсэн үндэстний байгууллагын практикт нийцүүлэн гаргадаг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын хэвлэл нийтлэлд Олон улсын хөдөлмөрийн товчооны зүгээс аливаа улс орон, бус, газар нутгийн болон эрх барих байгууллагын эрх зүйн байдал, эсвэл тэдгээрийн хил хязгаарыг тогтоохтой холбоотой ямарваа нэг үзэл бодол илэрхийлдэггүй болно.

Зохиогчтой өгүүлэл, судалгаа болон бусад нийтлэлд илэрхийлэгдсэн үзэл бодлын талаарх хариуцлагыг гагцхүү тэдгээрийг зохиогч хүлээх бөгөөд Олон улсын хөдөлмөрийн товчоо хэвлэл нийтэлсэн нь тэдгээрт илэрхийлсэн үзэл бодлыг зөвшөөрсөн хэрэг биш юм.

Фирмийн нэр болон арилжааны зориулалттай бүтээгдэхүүн, технологийн үйл явцын талаар дурдсан нь Олон улсын хөдөлмөрийн товчооны зүгээс тэдгээрийг сайшааж байгааг илэрхийлэхгүй бөгөөд тодорхой фирм, арилжааны зориулалттай бүтээгдэхүүн, технологийн үйл явцыг дурдалгүй орхигдуулсан бол энэ нь тэдгээрийг үгүйсгэсэн явдал биш болно.

ОУХБ-ын хэвлэл нийтлэл болон цахим бүтээгдэхүүнүүдийг томоохон номын худалдаа, эсвэл цахим мэдээллийн сангаас авах буюу ilo@turpin-distribution.com гэсэн и-мэйлээр шууд захиалан авч болно. Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.ilo.org/publns вэб сайт, ilopubs@ilo.org и-мэйл хаягаар холбогдоно уу.

Монгол Улсад хэвлэв.

Өмнөх үг

Монгол Улс өнгөрсөн хорин жилд олон намын тогтолцоо бүхий ардчилсан нийгэмд амжилттай шилжин, эдийн засаг нь олон төрлөөр хөгжөөгүй ч хурдацтай өсчээ. Монголын эдийн засаг дэлхий нийтийн зах зээлд, ялангуяа Европын Холбоо, Америкийн Нэгдсэн Улс зэрэг худалдааны гол түншүүдтэй худалдаа, хөрөнгө оруулалтыг чөлөөлөх нөхцөл тогтоосноор улам бүр интеграцлагдав. Гэхдээ төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үеэс олон улсын болон үндэсний хүний эрхийн байгууллага, Монгол Улсын худалдааны түншүүдийн дунд сэтгэл зовоосон тодорхой зарим хэвшил дадал үлдэж хоцорсон байна. Тийм хэвшил дадлын нэг нь хугацаат цэргийн албан хаагчдыг цэргийн бус хөдөлмөр, эдийн засгийн бүтээн байгуулалтад ашиглаж буй практик юм.

Энэ тайланд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-ын Азийн бүс нутаг дахь албадан хөдөлмөрийн ажиллагаа (АБАХА) төслийн техник арга зүйн тусламжтайгаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын явуулсан судалгааны үр дүнг тусгасан болно. Судалгаагаар заавал хаах цэргийн алба болон хугацаат цэргийн хөдөлмөрийн талаарх Монгол Улсын эрх зүйн орчин, зохицуулалт, үйл ажиллагааг авч үзэв. Судалгааны ажлыг 2013 оны 6 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд барилга-инженерийн 339, 340 дүгээр ангид нийт 159 хүнийг санал асуулгад хамруулан хийж гүйцэтгэв.

ОУХБ-ын Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29 дүгээр конвенц нь заавал хаах цэргийн алба байхыг хүлээн зөвшөөрч байгаа боловч хугацаат цэргийн алба хаагчдыг гагцхүү цэвэр цэргийн шинжтэй ажил хөдөлмөрт дайчлахыг зөвшөөрдөг байна. Мөн түүнчлэн Албадан хөдөлмөрийг устгах тухай 1957 оны 105 дугаар конвенцод хугацаат цэргийн хаагчийг албадан хөдөлмөрлүүлэх болон аливаа этгээдийг эдийн засгийн хөгжлийн зорилгоор албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрт дайчлахыг хориглосон болно. Энэ судалгаагаар Монгол Улсын батлан хамгаалах бодлого дахь хугацаат цэргийн албан хаагчдыг эдийн засгийн бүтээн байгуулалтад оролцуулах илэрхий зорилго байгааг тогтоов. Судалгааны үр дүнгээс үзэхэд бодит байдалд хугацаат цэргийн албан хаагчдыг бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрийн хүрээнд цэргийн бус ажилд оролцуулдаг байна. Эдгээр баримтаас үүдэн Монгол Улс 2005 онд соёрхон баталсан ОУХБ-ын 29, 105 дугаар конвенцийн зүйл заалтыг дагаж мөрддөг эсэхэд эргэлзээ төрж байна.

Олон Улсын Хөдөлмөрийн Чуулганаас 2014 онд албадан хөдөлмөрийг устгах дэлхий нийтийн хүчин чармайлтыг бэхжүүлэхэд чиглэсэн хууль зүйн чадамж бүхий шинэ Протоколыг баталсан билээ. Энэ Протокол нь албадан хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, түүний хохирогчдыг хамгаалах, мөн эдийн болон бие махбодын хохирлын нөхөн төлбөр зэрэг нөхөн сэргээх боломжоор хангах арга хэмжээнд уриалан дуудсан шинэ санаачлага юм. Эдгээр шинэ стандарт нь хүн бүр зохистой ажил хөдөлмөр эрхлэхэд саад хийж, ядуурал амь бөхтэй оршиход нэрмээс болж буй албадан хөдөлмөрийн эсрэг авч буй алхам юм. Өдгөө дэлхий даяар албадан хөдөлмөрийн хохирогч болсон 21 сая хүн байна. Хувийн хэвшилд жил бүр орчин үеийн боолчлолын хэлбэрээр 150 сая орчим ам долларын хууль бус ашиг олж байна. 2030 он хүртэлх Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөрт оролцоо бүхий эдийн засгийн тогтвортой хөгжил, бүрэн, бүтээмжтэй ажил эрхлэлтийг хангаж, бүх нийтийн зохистой ажлын байрыг хангах өргөн зорилгын хүрээнд “албадан хөдөлмөрийг устгах, орчин үеийн боолчлол, хүний наймааг зогсоох үр нөлөөтэй арга хэмжээг нэн даруй авах” зорилт дэвшүүлсэн билээ (Тогтвортой хөгжлийн зорилт 8).

Энэхүү илтгэлд заавал хаах цэргийн албыг Монгол Улсын олон улсын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагад нийцүүлэн зохион байгуулахын тулд Монгол Улсын үндэсний хууль тогтоомж, бодлого, зохицуулалтад үнэлэлт өгч болох чиглэлүүдийг тодорхойлсон болно. Мөн энд бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрийн хүрээнд иргэний цалинтай ажлын байр бий болгон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлийг хөдөлмөр эрхлэлтийн ерөнхий хөтөлбөр, хөдөлмөрийн зах зээлийн бодлогодоо гол болгон баримтлахыг зөвлөмж болголоо. Энэ илтгэл Монгол Улс дахь хугацаат цэргийн хөдөлмөр, үндэсний хөгжлийн асуудлаарх болон олон улсад санал солилцоход чиглэсэн цаашид харилцан хэлэлцэх сэдэл болно гэж бид найдаж байна.

Монгол Улсын
Хүний эрхийн Үндэсний
Комиссын дарга

Ж.Бямбадорж

ОУХБ-ын БНХАУ,
Монгол Улсыг хариуцсан
товчооны захирал

Тим Дэ Мэйэр

Агуулга

Өмнөх үг.....	iii
Талархал	viii
Судалгааны тойм	ix
Товчилсон үгийн жагсаалт	xii
1. Судалгааны аргачлал.....	1
1.1 Нөхцөлбайдал.....	1
1.2 Судалгааны зорилго.....	2
1.3 Судалгааны арга зүй болон судалгаанд хамрагдсан байгууллага, хүмүүс.....	2
1.3.1 Санал асуулгын хэлбэр.....	3
1.3.2 Судалгаанд оролцогчид.....	3
2. Хугацаат цэргийн албан хаагчийн хөдөлмөрийн олон улсын эрх зүйн орчин.....	5
2.1 Хугацаат цэргийн албан хаагчийг цэргийн бус ажилд оролцуулахыг хориглох нь.....	5
2.2 Албадан хөдөлмөрийг эдийн засгийн бүтээн байгуулалтад ашиглахыг хориглох нь.....	6
3. Монгол Улсын хугацаат цэргийн албан хаагчийн хөдөлмөрийн эрх зүйн орчин.....	8
3.1 Цэргийн анги байгууллагыг аж ахуйн үйл ажиллагаанд оролцуулах журам.....	8
3.2 Зэвсэгт хүчний тухай хууль.....	9
3.3 Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр.....	10
3.4 Монгол цэрэг бүтээн байгуулалтад хөтөлбөр.....	10
4. Хугацаат цэргийн албан хаагчийн хөдөлмөрийн нөхцөл байдал.....	12
4.1 Судалгаанд хамрагдсан байгууллагуудын тухай.....	12
4.2 Хугацаат цэргийн албан хаагчдын эрхэлж буй	

цэргийн бус ажил.....	13
4.3 Сургалт.....	14
4.4 Цалин хөлс.....	15
4.5 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй.....	15
4.6 Хугацаат цэргийн албан хаагчийн цэргийн бус ажлын шинж...15	
5. Судалгааны дүн шинжилгээ, ОУХБ-ын зөвлөмж.....	16
5.1 Хугацаат цэргийн албан хаагчдыг цэргийн бус ажилд оролцуулж байгааг тогтоосон баримтууд.....	16
5.2 Хугацаат цэргийн албан хаагчдыг эдийн засгийн бүтээн байгуулалтад оролцуулж байгааг тогтоосон баримт бичиг..17	
5.3 Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын зөвлөмж.....	17
6. ХЭҮК-ын зөвлөмж, судалгааны үр дүн.....	19
6.1 ХЭҮК-ын зөвлөмж.....	19
6.2 Уулзалт, хэлэлцүүлэг.....	20
Ашигласан материал.....	21
Хавсралт I. Үр дүнгийн хурал: Оролцогчдын нэрс.....	22

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Оролцогчдыг насны бүлгээр авч үзвэл.....	4
Хүснэгт 2. Оролцогчдыг яс үндсээр ангилвал.....	4

Тоон мэдээллийн жагсаалт

Дүрс 1. Сургалтад хамрагдсан оролцогчдын хувь хэмжээ сургалтын агуулга, хэлбэр.....	14
--	----

Шигтгээний жагсаалт

Шигтгээ 1. Цэргийн ангийг цэргийн бус ажилд оролцуулах ажиллагааны үйл явц.....	9
--	---



Талархал

Энэхүү судалгааны төслийг Гомдол, хяналт шалгалт, бодлогын дүн шинжилгээний хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Ахлах референт Б.Батаа нараар ахлуулсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын баг гүйцэтгэсэн болно. Төслийн бүхий л үе шатанд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын ажилтан Маря Паавилайнен, Тим Дэ Мэйэр, П.Болормаа, Париссара Ливкит, Майкл Де Кок нар техникийн туслалцаа үзүүлж ажилласан юм. Одоогийн энэхүү тайланг Маря Паавилайнен, Жулия Боргианни Бато нар боловсруулж, Марко Стирмсек, Лю Зенин болон Ричард Хорн нар мэдээллийн дүн шинжилгээ хийхэд туслалцаа үзүүлсэн болно.

Судалгааны төсөлд гадаад, дотоодын олон мэргэжилтнүүд ихээхэн хувь нэмэр оруулсан болно. Эн тэргүүнд барилга-инженерийн 339, 340 дүгээр ангийн хугацаат цэргийн албан хаагчдад талархал илэрхийлье. Тэдний оролцоогүйгээр энэ судалгааг хийх боломжгүй байсан юм. Дээрх хоёр барилга-инженерийн цэргийн ангид судалгааг хийх боломж олгосон Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штабын удирдлагад гүн талархал илэрхийлж байна.

Судалгааны үр дүнг Хүний эрхийн Үндэсний Комиссын байранд зохион байгуулсан үр дүнгийн хурлаар хэлэлцэв. Бид мөн энэ дүнгийн хурлын үеэр мэдлэг, туршлагаа харамгүй хуваалцсан бүх хүмүүст талархал илэхийлье.

Энэхүү хэвлэлийг ОУХБ-ын “Азийн бүс нутаг дахь албадан хөдөлмөрийн ажиллагаа” төслөөр дамжуулан Ирландын Засгийн газрын гадаад хөгжлийн хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэвлүүлэв.

Энэхүү хэвлэлд туссан санал бодол, байр суурь зэрэг нь бүхэлдээ зохиогчийнх бөгөөд Ирландын Засгийн газрын гадаад хөгжлийн хөтөлбөрийн бодлогыг илэрхийлэхгүй болно.

OH.HMN
СУДАЛГААНЫ САН

Судалгааны тойм

Монгол Улсад заавал хаах цэргийн алба нэг жил бөгөөд 18-25 насны бүх эрчүүд хаах ёстой юм.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК) хугацаат цэргийн албан хаагчдыг бүтээн байгуулалтын зориулалттай цэргийн бус ажилд оролцуулдаг талаар мэдээлэл авч байсан бөгөөд үүнээс үүдэн энэ практик нь Монгол Улсын нэгдэн орсон Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29 дүгээр конвенц, Албадан хөдөлмөрийг устгах тухай 1957 оны 105 дугаар конвенцийн заалттай нийцэх эсэх талаар асуудал үүсч байлаа. ХЭҮК нь Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас практик судалгаа явуулахад дэмжлэг үзүүлэхийг хүссэн юм. Үүний үр дүнд 2013 онд ОУХБ-ын Азийн бүс нутаг дахь албадан хөдөлмөрийн ажиллагаа төслөөс (АБАХА) Монгол Улс дахь хугацаат цэргийн албан хаагчийг ашиглаж байгаа бодлого, зохицуулалтын судалгаа явуулахад нь ХЭҮК-т дэмжлэг үзүүлэв. Судалгаанд армийн хоёр анги хамрагдав.

Зэвсэгт Хүчний 339, 340 дүгээр ангид 2013 оны 6-наас 9 дүгээр сарын хооронд судалгаа хийв. Нийт 159 хүн уг судалгаанд оролцов.

Хугацаат цэргийн албан хаагчийн цэргийн бус хөдөлмөртэй холбоотойгоор тогтоосон баримтууд

Монгол Улс дахь одоогийн хууль тогтоомж, эрх зүйн орчны хүрээнд заавал хаах цэргийн албанд татагдсан хүнээр цэвэр цэргийн шинжгүй ажил буюу цэвэр цэргийн зориулалтаар гүйцэтгэх ажил, хөдөлмөр хийлгэх боломжтой байна. Газар дээр нь хийсэн судалгаагаар бодит байдалд **339, 340 дүгээр цэргийн ангийн хугацаат цэргийн албан хаагчдаар цэргийн бус ажил гүйцэтгүүлдэг** байна. Энэ нотолгооноос үүдэн 29 дүгээр конвенцийн зүйл заалтыг дагаж мөрддөг эсэхэд эргэлзээ төрж байна.

Судалгааны үр дүнгээс үзвэл судалгаанд оролцсон хугацаат цэргийн албан хаагчдын олонх нь цэргийн шинжгүй ажил сайн дурын үндсэнд гүйцэтгэдэг ажээ. Тэдний ихэнх нь тийм ажил хийснийхээ төлөө цалин хөлс авдаг бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн наад захын нөхцөлд ажилладаг байна. Гэсэн хэдий ч энэ байдал нь мөн 29 дүгээр конвенцоор зөвшөөрсөн хугацаат цэргийн албан хаагчид цэргийн биш ажил эрхэлж болох конвенцийн заалттай нийцэхгүй байна. Тэрхүү ажлыг мөн л цэргийн албаны үүргийн дагуу гүйцэтгэж

байх тул 29 дүгээр конвенцоор хориглосон албадан хөдөлмөрийн тодорхойлолтод хамаарна.

Цэргийн биш ажил, хөдөлмөр нь цэргийн мэргэжлийн бэлтгэл, сургуулилтын зорилгыг агуулж байвал хугацаат цэргийн албан хаагчаар тийм ажил хийлгэхийг 29 дүгээр конвенцод зөвшөөрч болно. Энэхүү судалгааны хүрээнд цуглуулсан хугацаат цэргийн албан хаагчдаар хийлгэх мэргэжлийн бэлтгэл, сургуулилтын талаарх баримт нотолгооноос үзвэл барилга-инженерийн цэргийн 339, 340 дүгээр ангид дээрх шаардлагыг хангасан гэж дүгнэж болохоор дэлгэрэнгүй байж чадаагүй юм.

Хугацаат цэргийн албан хаагчдыг эдийн засгийн бүтээн байгуулалтад оролцуулах тухай баримт бичгүүд

Монгол Улсын батлан хамгаалах бодлогын хүрээнд **2012–2016 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Цэргийн алба хаагчдыг шинэ бүтээн байгуулалтад оролцуулах арга хэмжээ авах”** зорилт тусгагдсан байна. Монгол Улсын Засгийн газар 2013 онд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор цэргийн алба хаагчдыг бүтээн байгуулалтын ажилд оролцуулахын тулд “Монгол цэрэг бүтээн байгуулалтад” хөтөлбөрийг баталсан байна. Эдгээр бодлого зохицуулалтаар зэвсэгт хүчний байнгын бүрэлдэхүүн болон хугацаат цэргийн албан хаагчдыг цэргийн бус үйл ажиллагаанд татан оролцуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. Энэ судалгааны үр дүнгээс үзвэл **хугацаат цэргийн албан хаагчдыг бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрийн хүрээнд цэргийн бус ажил гүйцэтгүүлдэг** байна. Энэ баримт нотолгооноос үүдэн эдийн засгийн бүтээн байгуулалтын зорилгоор заавал хийх хөдөлмөрт дайчлан хэрэглэхийг хориглосон 105 дугаар конвенцийн зүйл заалтыг дагаж мөрддөг эсэхэд эргэлзээ төрж байна.

ОУХБ-ын зөвлөмж

1. Хууль тогтоомж, эрх зүйн орчинд өөрчлөлт оруулж заавал хаах цэргийн алба хааж буй хүмүүсийг мэргэжлийн арга, техник эзэмших сургалтын хүрээнээс буюу нарийвчлан тодорхойлсон онц байдал үүссэн нөхцөл байдлаас гадуур цэргийн бус ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй байх баталгааг хангах.
2. Эрх зүйн орчин болон бодит практикт хөдөлмөр эрхлэлт,

хөгжлийн хөтөлбөрт хамрагдах оролцоог сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх. Заавал хаах цэргийн алба хааж буй хүмүүсийг эдийн засгийн бүтээн байгуулалтын зорилгоор ашиглахаас татгалзах.

3. Заавал хаах цэргийн албаны хугацааг үндэсний батлан хамгаалах бодит шаардлагад нийцүүлэх. Бодлогын бусад зорилтыг (жишээ нь ажилгүйдлийг бууруулах, мэргэжлийн ур чадвар олгох зэрэг) иргэдийг албан үүрэгт дайчилгаагаар гэхээсээ хөдөлмөрийн зах зээлийн зорилтот бодлогоор шийдвэрлэж байх.

ХЭҮК-ын зөвлөмж, судалгааны үр дүн

Судалгаагаар тогтоосон нөхцөл байдалд тулгуурлан ХЭҮК Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Батлан хамгаалах яам болон Зэвсэгт хүчний жанжин штабт зөвлөмж хүргүүлсэн юм. Эдгээр зөвлөмж болон судалгааны эхний үр дүнг 2013 онд Батлан хамгаалах яамны төлөөллийг оролцуулан хийсэн хурлаар хэлэлцэв.

Дээрх зөвлөлдөх хурлын үед Батлан хамгаалах яамны төлөөлөл ХЭҮК-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хэсэг гаргахаа мэдэгдэв. Уг ажлын хэсэг нь эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал төлөвлөх, олон улсын гэрээ конвенцийг хэрэгжүүлэх арга хэмжээ авна. Мөн Зэвсэгт хүчний жанжин штабын төлөөлөл ХЭҮК-ын гаргаж тавьсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээ авах талаар санал нийллээ. 2015 оны 12 дугаар сарын байдлаар Монгол Улсад ХЭҮК-ын зөвлөмжид туссан албадан хөдөлмөрийг зохицуулсан холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд зохих нэмэлт өөрчлөлт оруулах буюу тэдгээрийг шинэчлэн найруулах ажил хийгээгүй байв.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Товчилсан үгийн жагсаалт

КЗХХШХ	Конвенц, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах шинжээчдийн хороо (ОУХБ)
АБАХА	Азийн бүс нутаг дахь албадан хөдөлмөрийн ажиллагаа төсөл (ОУХБ)
ОУХБХ	Олон Улсын Хөдөлмөрийн Чуулган
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний Комисс

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

1. Судалгааны аргачлал

1.1 Нөхцөл байдал

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагын статусын талаарх зарчимд (Парисын зарчим) нийцсэн, Монгол Улсын Их Хуралд илтгэл өргөн барьдаг хүний эрхийн үндэсний байгууллага юм. ХЭҮК нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, мөн Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг хүлээнэ. Эрх хэмжээнийхээ хүрээнд Комисс нь хүний эрхийг зөрчсөн талаар хүлээн авсан мэдээлэлд үндэслэн өөрийн санаачлагаар, эсхүл аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүсэлтээр хяналт шалгалт явуулах бүрэн эрхтэй.¹

Хяналт тавих үйл ажиллагааны явцад Комисс нь хугацаат цэргийн албан хаагчаар цэргийн биш гэж болохоор барилгын болон аж ахуйн ажил гүйцэтгүүлж байгаа тухай тохиолдлуудыг олж тогтоосон болно. Иймд тийнхүү ажил хийлгэж байгаа нь албадан хөдөлмөрийн асуудлыг зохицуулсан олон улсын хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэхийг тодорхойлохын тулд нэмэлт судалгаа хийх шаардлагатай болов. ОУХБ-ын Азийн бүс нутаг дахь албадан хөдөлмөрийн ажиллагаа төсөл (АБАХА) 2013 онд ХЭҮК-т Монгол Улс дахь хугацаат цэргийн албан хаагчдын гүйцэтгэж байгаа хөдөлмөрийн шинж байдалд бодлого, үйл ажиллагааны үнэлгээ хийхэд нь дэмжлэг үзүүлсэн юм. Энэ судалгааны хүрээнд сонгон авсан барилга-инженерийн цэргийн хоёр ангид хөдөлмөр эрхлэлтийн байдалд тоон судалгаа хийлээ.

Монгол Улс Албадан хөдөлмөрийн тухай ОУХБ-ын 1930 оны 29 дүгээр конвенц болон Албадан хөдөлмөрийг устгах тухай 1957 оны 105 дугаар конвенцийг 2005 онд соёрхон баталсан билээ. Үндэсний хууль тогтоомж, бодлого, зохицуулалтыг дээрх конвенцуудад нийцүүлэхээр ихээхэн хүчин чармайлт гаргасан хэдий ч бүрэн ажил хэрэг болгоход саад бэрхшээл тулгарсаар байна. Үүнтэй холбогдуулан ОУХБ-ын Конвенц, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах Шинжээчдийн Хороо (цаашид Шинжээчдийн Хороо гэх) Засгийн газраас хугацаат цэргийн гүйцэтгэж байгаа ажлын талаар болон заавал хаах цэргийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу хааж буй албыг цэвэр цэргийн

¹ Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 18 дугаар зүйл.

зориулалттай ашигладаг болохыг баталсан мэдээлэл өгөхийг хүссэн юм.²

1.2 Судалгааны зорилго

Судалгааны зорилго нь Монгол Улсын хугацаат цэргийн албан хаагчдын гүйцэтгэж буй ажил хөдөлмөр ОУХБ-ын 29, 105 дугаар конвенцийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлэхэд оршив.

Ялангуяа, судалгаанд дараах зорилтыг тавив. Үүнд:

1. Судалгаагаар Монгол Улсад хугацаат цэргийн албан хаагчийн гүйцэтгэж байгаа ажлын байдлыг баримтжуулах;
2. Заавал хаах цэргийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу хийж буй ажил, үйлчилгээ нь ОУХБ-ын 29, 105 дугаар конвенцийн шаардлагад нийцэж буй эсэхэд үнэлэлт өгөх;
3. Заавал хаах цэргийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд хийж буй ажилтай холбоотой хууль тогтоомж, бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох талаар холбогдох байгууллагад зөвлөмж өгөх;
4. ОУХБ-ын 29, 105 дугаар конвенцийн хугацаат цэргийн албан хаагчдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний талаарх зүйл заалтын тухай мэдлэг ойлголтыг дээшлүүлэх.

1.3 Судалгааны арга зүй болон судалгаанд хамрагдсан байгууллага, хүмүүс

ОУХБ-ын дэмжлэгтэйгээр ХЭҮК-ын явуулсан судалгааны хүрээнд Монгол Улсад хугацаат цэргийн албан хаагчдаар гүйцэтгүүлж буй ажил, хөдөлмөрийн талаарх бодлого, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийв. Баримт мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд барилга-инженерийн чиг үүрэг бүхий цэргийн гурван ангийн хоёрт нь очиж судалгаа хийв. Газар дээрх судалгааг 2013 оны 6 дугаар сарын 12 болон 9 дүгээр сарын 2-ны өдөр хийлээ.

Судалгаанд хамрагдах газруудыг ерөнхий шинж чанар, байрлах байршил зэргийн хувьд ялгаатай цэргийн ангиудыг төлөөлөх байдлыг нь тооцож сонгон авсан нь:

² ОУХБ-ын КЗХХШХ. 2009, 2011, 2013 он. Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29 дүгээр Конвенцийн хэрэгжилтийн тухай шууд хүсэлт. <http://www.ilo.org/normlex> [2015 оны 5 дугаар сарын 17-ны өдөр үзэв].

- Улаанбаатар хотоос 630 км зайд Баянхонгор аймагт орших барилга-инженерийн цэргийн 339 дүгээр анги;
- Улаанбаатар хотоос 1,630 км зайд Баян-Өлгий аймагт орших барилга-инженерийн цэргийн 340 дүгээр анги.

Энэ ангиуд нь Зэвсэгт хүчний жанжин штабын харьяанд байдаг ангиуд юм.

Монгол Улсын зэвсэгт хүчинд бүртгэлтэй иргэдийн тоо 2013 оны байдлаар 144,500 байсны 17,500 нь идэвхтэй цэргийн алба хааж буй хүмүүс байв (Дэлхийн Банк, 2013 он). 2010 оны тооллогоор Монгол Улсын хүн ам 2.8 сая орчим байлаа (Үндэсний Статисткийн Хороо, 2010 он). Гэвч судалгааны үр дүн нь Монгол Улсын нийт зэвсэгт хүчнийг төлөөлөхгүй болно.

1.3.1 Санал асуулгын хэлбэр

Судалгааны санал асуулгыг ХЭҮК болон ОУХБ-ын Азийн бүс нутаг дахь албадан хөдөлмөрийн ажиллагаа төсөл (АБАХА) хамтран боловсруулсан юм. Санал асуулга дараах хэсгүүдээс бүрдэв. Үүнд:

А хэсэг: Оролцогчийн хувийн мэдээлэл

Б хэсэг: Хугацаат цэргийн албан хаагчийн сургалт, хөдөлмөртэй холбоотой асуудлууд

В хэсэг: Цэргийн бус шинжтэй ажилтай холбоотой асуудлууд

Г хэсэг: Хугацаат цэргийн албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлууд

Д хэсэг: ХЭҮК-т тавих санал хүсэлт.

Санал асуулгаас гадна судалгааны арга зүйн хүрээнд ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага, заавал хаах цэргийн албаны талаарх үндэсний хууль тогтоомж, бодлого зохицуулалтын талаарх эрх зүйн орчны шинжилгээг ашиглалаа. Ганцаарчилсан ярилцлагад оролцсон хүмүүст судалгааг хаанаас явуулж байгаа болон судалгааны хамрах хүрээг танилцуулж, оролцох зөвшөөрлийг авсан болно.

1.3.2 Судалгаанд оролцогчид

Санал асуулгад оролцсон нийт 159 хүн бүгд эрэгтэй байв. 1, 2 дугаар хүснэгтэд эдгээр оролцогчдын үндсэн мэдээллийг харуулав.

Хүснэгт 1: Оролцогчдыг насны бүлгээр авч үзвэл

Насны бүлэг	Оролцогчдын тоо
18 хүртэл	1
18-30	144
31-44	13
45+	1
Нийт	159

Хүснэгт 2: Оролцогчдыг яс үндсээр ангилвал

Яс үндэс	Оролцогчдын тоо
Монгол	151
Казах	3
Тува	0
Бусад	5
Нийт	159

Судалгаанд оролцогчид нь хугацаат цэргийн албан хаагчид болон зэвсэгт хүчний байнгын бүрэлдэхүүний албан хаагчид байлаа. Гэвч заавал хаах цэргийн албатай холбоотой 29 болон 105 дугаар конвенцийн заалтууд нь сайн дураар алба хааж буй байнгын бүрэлдэхүүний албан хаагчдад үл хамаарах тул санал асуулга зөвхөн хугацаат цэргийн алба хаах үед хамаарна.



2. Хугацаат цэргийн хөдөлмөрийн талаарх олон улсын хэм хэмжээ

Заавал хаах цэргийн албаны хүрээнд гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний тухай олон улсын хэм хэмжээг энэ талаарх олон улсын хоёр гол конвенц болох ОУХБ-ын 29 болон 105 дугаар конвенцоор тогтоож өгсөн юм.

2.1 Хугацаат цэргийн албан хаагчийг цэргийн бус ажилд оролцуулахыг хориглох нь

ОУХБ-ын 29 дүгээр конвенцод хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх бүх хэлбэрийг хоригложээ. Конвенцийн 2 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт тодорхойлсноор албадан буюу заавал хийх ажил гэж:

ямар нэг шийтгэл хүлээлгэхээр айлган сүрдүүлж аливаа этгээдээр гүйцэтгүүлэх, чингэхдээ уг этгээд нь өөрөө сайн дураар гүйцэтгэхийг санал болгоогүй бүх ажил буюу үйлчилгээг хэлнэ.

Гэхдээ заавал хийх ажил, хөдөлмөрийн тодорхой хэлбэрүүдийг албадан буюу заавал хийх хөдөлмөрийн дээрх тодорхойлолтод хамааруулдаггүй юм. Үүнийг Конвенцийн 2 дугаар зүйлийн (2)(а) хэсэгт дараах байдлаар дурджээ. Үүнд:

цэргийн алба заавал хаахыг заасан хуулийн дагуу цэвэр цэргийн шинжтэй ажил гүйцэтгэхтэй холбогдсон аливаа ажил буюу үйлчилгээ.

Цэргийн заавал хаах албаны хүрээнд хамаарах ажлыг цэвэр цэргийн шинжтэй байх зэрэг тодорхой хязгаартай нөхцөлд л албадан хөдөлмөрт хамааруулдаггүй юм. Цэвэр цэргийн ажил, үйлчилгээнд тавих шаардлага нь хугацаат цэргийн албан хаагч үндэсний батлан хамгаалах зорилгын төлөө үйлчлэх үүрэг даалгавар гүйцэтгүүлдэг байх баталгааг хангахад чиглэнэ.³

Гэвч заавал хаах цэргийн албанд гүйцэтгүүлэх цэргийн биш үйл

³ Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ). 2007 он. Женев хотноо 2007 онд болсон Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 96 дугаар хуралдаан, III тайлан (1В хэсэг) Албадан хөдөлмөрийг устгах нь, Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29 дүгээр Конвенц, Албадан хөдөлмөрийг устгах тухай 1957 оны 105 дугаар Конвенцтой холбоотой Ерөнхий судалгаа, 43 дугаар догол мөр.

ажиллагааг албадан хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн олон улсын хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрч болох нөхцөлийг нарийвчлан заасан болно. ОУХБ-ын Шинжээчдийн Хороо батлан хамгаалах зорилго бүхий сургалтаас гадна хугацаат цэргийн албан хаагчид иргэний аж байдалд эргэн ороход нь тус дөхөм болох ерөнхий боловсролын болон мэргэжлийн сургалтад байнга хамрагддаг болохыг тэмдэглэсэн байна. Эдгээр зохицуулалт нь цэвэр сургалтын шинжтэй тул 29 дүгээр конвенцийн зориулалтаар “ажил буюу үйлчилгээ” гэж үзэхгүй юм.⁴ Инженерийн буюу түүнтэй төстэй цэргийн ангид алба хааж буй хугацаат цэргийн албан хаагчдаас зам, гүүр барих ажилд цэргийн бэлтгэл, сургуулилалтын хүрээнд оролцуулж болохоор байна.⁵

Мөн хугацаат цэргийн албан хаагч бусад иргэний адилаар онцгой байдал үүссэн тохиолдолд (29 дүгээр конвенцод тодорхойлсноор) ажиллах буюу тийм нөхцөлд ердийн журмаар бол иргэний байгууллагад хариуцуулдаг цэвэр цэргийн бус шинжтэй ажил үйлчилгээг гүйцэтгэж болно.⁶

Дээрх журам нь зөвхөн заавал хаах цэргийн албанд л хамаарах бөгөөд байнгын бүрэлдэхүүний цэргийн албан хаагчид хамаарахгүй юм. Энэ тайланд авч үзсэн 29 дүгээр конвенцийн агуулга нь зэвсэгт хүчинд сайн дурын үндсэн дээр алба хааж буй хүмүүст хамаарахгүй бөгөөд тийм ч учраас эдгээр хүмүүсийн цэргийн биш ажил гүйцэтгэхийг хориглоогүй болно.⁷

2.2 Албадан хөдөлмөрийг эдийн засгийн бүтээн байгуулалтад ашиглахыг хориглох нь

Заавал хаах цэргийн албаны хүрээнд гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний талаарх дээрх шаардлага нь нийгэмд тустай хөдөлмөрт цэрэг

⁴ ОУХБ. 1979 он. Женев хотноо 1979 онд болсон Олон Улсын Хөдөлмөрийн Бага Хурал 65 дугаар хуралдаан. III хуралдаан (4В хэсэг), Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29 дүгээр Конвенц, Албадан хөдөлмөрийг устгах тухай 1957 оны 105 дугаар Конвенцтой холбоотой Ерөнхий судалгаа, 29 дүгээр догол мөр.

⁵ Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ). Женев хотноо 2007 онд болсон Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагын 96 дугаар хуралдаан, III тайлан (1В хэсэг) Албадан хөдөлмөрийг устгах нь, Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29 дүгээр Конвенц, Албадан хөдөлмөрийг устгах тухай 1957 оны 105 дугаар Конвенцтой холбоотой Ерөнхий судалгаа. 44 дүгээр догол мөр.

⁶ ОУХБ. Женев хотноо 1979 онд болсон Олон Улсын Хөдөлмөрийн Бага Хурал 65 дугаар хуралдаан. III хуралдаан (4В хэсэг), Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29 дүгээр Конвенц, Албадан хөдөлмөрийг устгах тухай 1957 оны 105 дугаар Конвенцтой холбоотой Ерөнхий судалгаа, 27 дугаар догол мөр.

⁷ Мөн тэнд., 46 дугаар догол мөр.

дайчлахаас урьдчилан сэргийлэхэд чиглэж байна. Энэ хориг нь албадан буюу заавал хийх хөдөлмөрийг “эдийн засгийн хөгжлийн зориулалтаар хөдөлмөрийг дайчлах, хэрэглэх арга”⁸ хэмээн хориглодог 105 дугаар конвенцийн 1 дүгээр зүйлийн (b) хэсгийн заалтаас үүдэн гарчээ.

Залуучуудыг заавал хаах цэргийн албаны хүрээнд улс орны бүтээн байгуулалтад чиглэсэн үйл ажиллагаанд оролцуулж болох эсэхийг 1970 оны Олон Улсын Хөдөлмөрийн чуулганаар хэлэлцсэн бөгөөд үүнийг 29, 105 дугаар конвенцийн аль алинд нийцэхгүй гэж үзсэн байна.⁹ Энэ хориг нь эдийн засгийн хөгжлийн зориулалтаар дайчилгааны хөдөлмөр нь түрхэн зуур буюу дахин давтагдахгүй шинжтэй байх тохиолдолд ч хамаарна. Мөн цаашилбал Шинжээцдийн Хороо хугацаат цэргийн албан хаагчдад цэргийн болон цэргийн биш ажлаас сонгох сонголт өгсөн байх тохиолдолд ч тухайн ажил нь заавал хаах албаны үүргийн хүрээнд өгч байгаа сонголт учраас сайн дурын гэж үзэх боломжгүй гэж дүгнэжээ.¹⁰

Түүхэн нөхцөлийн хувьд 105 дугаар конвенцийг Дэлхийн II дайны үед Ази, Европ тивийн аль алинд албадан хөдөлмөрийг өргөн хүрээнд хэрэглэсний дараа 1957 онд, ялангуяа улс төрийн дарамт буюу эдийн засгийн хөгжлийн зориулалтаар албадан буюу заавал хийх ажил хөдөлмөрийг шинэ тутам ашиглаж байсныг шийдвэрлэхийн тулд баталжээ.

⁸ Мөн тэнд., 44 дүгээр догол мөр.

⁹ Мөн тэнд., 25 дугаар догол мөр, Залуучуудын Талаарх Тусгай Зөвлөмжийг боловсруулах ажлын хүрээнд хийсэн хэлэлцүүлэг, 1970 он (No. 136)..

¹⁰ Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ). Женев хотноо 2007 онд болсон Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагын 96 дугаар хуралдаан, III тайлан (1В хэсэг) Албадан хөдөлмөрийг устгах нь, Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29 дүгээр Конвенц, Албадан хөдөлмөрийг устгах тухай 1957 оны 105 дугаар Конвенцтой холбоотой Ерөнхий судалгаа. 45 дугаар догол мөр.

3. Монгол Улс дахь хугацаат цэргийн албан хаагчдын хөдөлмөрийн эрх зүйн орчин

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах”-ыг Монгол Улсын иргэний үндсэн үүрэг болгосон байна. Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т 18-25 насны эр хүн бүр цэргийн албыг заавал хаахаар заажээ.

Монгол Улсад цэргийн албан хаагчийг цэргийн бус үйл ажиллагаанд оролцуулах харилцааг 1999 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 153 дугаар зарлигаар баталсан “Цэргийн анги, байгууллагыг аж ахуйн ажилд оролцуулах журам” болон 2002 онд батлагдсан Зэвсэгт хүчний тухай хуулиар зохицуулж байна. Мөн Засгийн газраас 2013 оны 107 дугаар тогтоолоороо цэргийг бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд оролцуулахаа хоёрдмол утгагүй бодлогын зорилт болгон дэмжиж байна. Эдгээр журам, бодлого, зохицуулалт нь цэргийн байнгын бүрэлдэхүүний албан хаагчаар зогсохгүй хугацаат цэргийн албан хаагчийг мөн цэргийн бус үйл ажиллагаанд оролцуулах нөхцөлийг бүрдүүлжээ.

3.1 Цэргийн анги байгууллагыг аж ахуйн үйл ажиллагаанд оролцуулах журам

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 153 дугаар зарлигаар “Цэргийн анги, байгууллагыг аж ахуйн ажилд оролцуулах журам”-ыг 1999 онд баталжээ. Уг журмын 2 дугаар зүйлд Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд чухал ач холбогдол бүхий төсөл хэрэгжүүлж буй төр болон хувийн аж ахуйн байгууллагаас цэргийн зарим анги, байгууллагыг гэрээгээр ангийн байрлалаас гадна ажиллуулах эрх зүйн боломж олгосон байна.

Шигтгээ 1

Цэргийн ангийг цэргийн бус ажилд оролцуулж буй байдал

1999 оны “Цэргийн анги, байгууллагыг аж ахуйн ажилд оролцуулах журам”-ын дагуу цэргийн ангийг цэргийн бус ажилд оролцуулах үйл явцыг доор харуулав:

Зэвсэгт хүчний жанжин штабын дарга байгууллагын хүсэлтийг хүлээн авч Батлан хамгаалахын сайдад танилцуулж зөвшилцөх;

Зэвсэгт хүчний жанжин штабын дарга байгууллагын хүсэлтийг өөрийн саналын хамт Монгол Улсын Ерөнхийлөгчид бичгээр өргөн мэдүүлэх;

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвшөөрлийг үндэслэн Батлан хамгаалахын сайд тушаал гаргана;

Батлан хамгаалахын сайдын тушаалыг үндэслэн Зэвсэгт хүчний жанжин штабын дарга тушаал гаргана;

Зэвсэгт хүчний жанжин штабын даргын тушаалыг үндэслэн цэргийн анги, байгууллагын захирагч аж ахуйн ажилд оролцуулахаар хүсэлт гаргасан байгууллагын даргатай хоёр талын гэрээ байгуулах;

3.2 Зэвсэгт хүчний тухай хууль

Зэвсэгт хүчний албан хаагч, тэр дундаа хугацаат цэргийн албан хаагчийн гүйцэтгэх үйл ажиллагаатай холбогдуулан Зэвсэгт хүчний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт “Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зөвшөөрөл, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийн дагуу зэвсэгт хүчний бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр цэргийн зарим анги, байгууллагыг аж ахуй¹¹, бүтээн байгуулалтын ажилд оролцуулж болно.” гэж заасан ба мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.8-д зэвсэгт хүчний анги, байгууллагыг аж ахуй, бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журмыг тогтоох бүрэн эрхийг Монгол Улсын Ерөнхийлөгчид олгосон байдаг.

¹¹ Зэвсэг хэрэглэх шаардлагагүйгээр цэргийн албан хаагчаар гүйцэтгүүлэх цэргийн шинж чанаргүй хөдөлмөр.

Зэвсэгт хүчний тухай хуульд 2010 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр барилга-инженерийн чиг үүрэг бүхий цэргийн ангиуд Монгол Улсын Зэвсэгт хүчний төрөл цэргийн хүрээнд үйл ажиллагааны нь эрх зүйн зохицуулалт бий болсон байна. Дээрх нэмэлт өөрчлөлт оруулсан хуулийн 7 дугаар зүйлд зааснаар Зэвсэгт хүчин нь Зэвсэгт хүчний жанжин штаб, төрөл цэргийн штабууд, төрөл, мэргэжлийн цэргийн болон барилга инженер, ар тал, техникийн нэгтгэл, ангиуд, цэргийн сургууль, сургалт-эрдэм шинжилгээ, соёл, урлаг, эмнэлэг, хэвлэл мэдээлэл, аж ахуй, үйлчилгээний байгууллагатай байхаар болжээ.

3.3 2012–2016 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөр

Батлах хамгаалах бодлогын хүрээнд **2012–2016 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Цэргийн алба хаагчдыг шинэ бүтээн байгуулалтад оролцуулах арга хэмжээ авах”** зорилт тусгагдсан байна.¹²

Уг зорилтын хүрээнд:

1. Дэд бүтцийг хөгжүүлэх, улс орны хэмжээний томоохон бүтээн байгуулалтад цэргийн хүчнийг оролцуулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
2. Барилга, инженерийн ангиудыг бие бүрэлдэхүүн, бүтээмж өндөртэй техник, тоног төхөөрөмжөөр хангаж, томоохон бүтээн байгуулалтын ажилд оролцуулах төрийн өмчит үйлдвэрийн газрын статустай болгох;
3. Улс орны хөгжлийн бүтээн байгуулалтыг дэмжих хүрээнд сургалт-үйлдвэрлэлийн төв байгуулж, цэргийн алба хаагчдыг сургах, мэргэшүүлэх үйл ажиллагааг нь эхлүүлэх;
4. Бүтээн байгуулалтад оролцох мэргэшсэн анги, салбаруудыг бүсчлэн байгуулж, бүс нутгийн хөгжлийг дэмжих;
5. Ойжуулах, цөлжилттэй тэмцэх, байгалийг нөхөн сэргээх болон экологийн төрөл бүрийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд цэргийн хүчний оролцоог нэмэгдүүлэх зорилтууд оржээ.

3.4 “Монгол цэрэг бүтээн байгуулалтад” хөтөлбөр

Монгол Улсын Засгийн газар 2013 оны 107 дугаар тогтоолоороо “Монгол цэрэг бүтээн байгуулалтад”¹³ хөтөлбөрийг баталсан байна.

¹² <http://www.legalinfo.mn/annex/details/5732?lawid=8859>

¹³ <http://www.legalinfo.mn/annex/?lawid=9124>

Уг хөтөлбөр нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор цэргийн алба хаагчдыг бүтээн байгуулалтын ажилд оролцуулах, стратегийн болон цэргийн тусгай зориулалтын объект, байгууламжийг барих, засвар үйлчилгээ хийх, хөдөлмөрийн насны залуусыг ажлын байраар хангах, орлогыг нь дээшлүүлэх замаар үндэсний ажиллах хүчний төлөвшилд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг батлан хамгаалах салбарын хэмжээнд зохион байгуулах зорилготой батлагджээ. (2.1 дэх заалт)

Уг хөтөлбөрийн дагуу инженерийн боловсрол бүхий цэргийн дээд мэргэжилтэй алба хаагчид, Зэвсэгт хүчний бүтцэд байгуулагдсан барилга, инженерийн ангиудын албан хаагчдыг уул уурхай, барилга, хот байгуулалт, дэд бүтцийн салбарт бүтээн байгуулалтын ажил болон техник, тоног төхөөрөмж, машин механизмын ашиглалт, засвар үйлчилгээ, тээвэрлэлтийн ажилд оролцуулж болохоор болжээ. (1 дэх заалт).

Хөтөлбөрийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т зааснаар цэргийн алба хаагчдыг бүтээн байгуулалтын ажилд оролцуулахдаа Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний заалтуудыг мөрдлөг болгон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг бүрэн хангасан, олон улсын болон Монгол Улсын стандартад нийцсэн нөхцөлд ажиллуулна. Бүтээн байгуулалтад оролцох цэргийн алба хаагчдад тухайн ажлын байрны үндсэн цалинг олгоно хэмээн заажээ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

4. Хугацаат цэргийн албан хаагчийн хөдөлмөрийн нөхцөл байдал

ХЭҮК хугацаат цэргийн албан хаагчийг цэргийн бус ажилд оролцуулж байгаа байдлыг баримтжуулахын тулд барилга-инженерийн цэргийн хоёр ангид очиж судалгаа хийлээ. Судалгааг 2013 оны 6 дугаар сарын 12-ны өдрөөс 9 дүгээр сарын 2-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

4.1 Судалгаанд хамрагдсан байгууллагуудын тухай

Судалгаанд хамрагдах байгууллагуудыг ерөнхий шинж чанар, байршлын хувьд нийт цэргийн ангиудыг төлөөлөх байдлыг нь тооцож, барилга-инженерийн цэргийн 339, 340 дүгээр ангийг сонгож авав. Эдгээр анги нь Зэвсэгт хүчний жанжин штабын харьяанд байдаг ангиуд юм.

Барилга-инженерийн цэргийн 339 дүгээр анги Улаанбаатар хотоос 630 км зайд Баянхонгор аймагт байрладаг бөгөөд Засгийн Газрын 2013 оны 114 дүгээр тогтоолоор байгуулагдсан байна.

Засгийн газар 2013 оны 3 дугаар сард “Монгол цэрэг бүтээн байгуулалтад” хөтөлбөр баталсны дараа 2013 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр ангийн захирагч “Гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдыг бүтээн байгуулалтын ажилд оролцуулах тухай” А/73 тоот тушаал гаргаж мөрдүүлжээ.

Барилга-инженерийн цэргийн 340 дүгээр анги Улаанбаатар хотоос 1,630 км зайд Баян-Өлгий аймагт оршдог. Тус цэргийн анги нь “Улс орны бүтээн байгуулалтад оролцох, олон улсын энхийг дэмжих болон хүмүүнлэгийн үйл ажиллагаанд барилга, инженерийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж оролцуулах” зорилготойгоор 2010 онд байгуулагдсан байна. Тус анги дараах үндсэн чиг үүрэгтэй. Үүнд:

- Баруун аймгуудын нутаг дэвсгэрт гарсан байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, үйлдвэрлэлийн осол, аюул, хөнөөх хэрэгслийн хөнөөлийн голомтод байгаа хүн ам, эд баялгийг авран хамгаалахад болон тогтоосон хорио, цээрийн дэглэмийг сахиулахад туслах;
- болзошгүй террорист үйлдлийн эсрэг тусгай ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

- Улсын онц чухал объектийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх;
- баруун аймгуудын бүтээн байгуулалтад барилга инженерийн чиглэлээр оролцох.

4.2 Хугацаат цэргийн албан хаагчдын эрхэлж буй цэргийн бус ажил

Судалгаа хийх үед 339, 340 дүгээр ангид алба хааж байсан хугацаат цэргийн албан хаагчдыг цэргийн бус шинжтэй ажилд оролцуулж байлаа.

339 дүгээр ангийн хугацаат цэргийн олон албан хаагч болон офицер, ахлагч нар албан тушаалын орон сууцны барилга угсралтын ажлыг хариуцан гүйцэтгэж байв. Өмнөх жилүүдэд ангийн захирагч нь цэргийн албан хаагчдыг анги, хувь хүн, аж ахуйн нэгж, төрийн байгууллагын хооронд гэрээ байгуулсны үндсэн дээр ажил гүйцэтгүүлсэн байна. Эдгээр нь аймгийн онцгой байдлын хэлтсийн авто гражийн барилгын их засварыг гүйцэтгэх ажил, орон сууцны барилгын ажил гүйцэтгэх гэрээнүүд байв.

340 дүгээр ангийн дийлэнх бие бүрэлдэхүүн Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт байрлах Асгат гэх газар зам барилгын ажилд оролцохоор томилогдон явсан байв. Өмнөх жил нь хувь хүн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан хугацаат цэргийн албан хаагч зэрэг албан хаагчдаар барилга угсралтын ажил гүйцэтгүүлсэн байна. Эдгээрт байшингийн дээврийн цутгалтын ажил, орон сууцны зоорийн давхрын хучилтыг хийх үеийн барилгын туслах ажил, машин дээр тоосго ачих, түүхий тоосго талбайд хураах, бетон зуурмаг зууруулах, зөөвөрлөх, хувийн эмнэлэг, ресторан, сумын хэсгийн төлөөлөгчийн байрны барилгын өргөтгөлийн ажилд туслах ажил гэх мэт болно.



Зураг 1. Барилгын талбайд ажиллаж буй 339 дүгээр ангийн хугацаат цэргийн албан хаагчид, ахлагч нар




Зураг 2. Замын барилгын ажил гүйцэтгэж буй 340 дүгээр ангийн хугацаат цэргийн албан хаагчид судалгааны асуултад хариулж байгаа нь

4.3 Сургалт

Судалгаа хийх үед 339, 340 дүгээр ангиуд хугацаат цэргийн албан хаагчдадаа техник, арга зүйн сургалт явуулсан байлаа. 340 дүгээр анги орон нутгийн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвтэй хамтран хугацаат цэргийн албан хаагчдад сургалт явуулжээ.

Сургалтын талаарх асуултад судалгаанд оролцсон 115 албан хаагчийн 64 нь буюу 55.65 хувь нь заавал хаах цэргийн албанд зөвхөн цэргийн суурь эрдмийн сургалт ордог гэж хариулав. Нийт 31 албан хаагч буюу 26.96 хувь нь тэдний сургалтын хүрээнд заавал сурах барилгын сургалт орсон гэсэн бол 11 оролцогч буюу 9.57 хувь нь инженерийн ур чадварын сургалт заавал хамрагдах сургалтаар орсон гэжээ.



4.4 Цалин хөлс

Цалин, хөлсний талаарх асуултад судалгаанд оролцогчдын дийлэнх олонх нь (95 хувь нь буюу нийт 140 оролцогчийн 133 нь) цэргийн бус ажил, хөдөлмөр гүйцэтгээд цалин хөлс авдаг гэж хариулав. Цалин олгох хэлбэрийн хувьд 130 оролцогчийн 90 нь буюу 69 хувь нь цалинг нь хугацаат цэргийн нэрийн дансанд нь шилжүүлдэг гэв. 19 гаруй хувь нь буюу 25 оролцогч бэлнээр цалингаа авдаг гэсэн бол 12 орчим хувь нь буюу 15 оролцогч бэлэн мөнгөөр биш буюу эд бараагаар орлуулан авсан гэжээ.

4.5 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хувьд судалгаанд оролцсон 143 албан хаагчийн 10 нь буюу 7 хувь нь цэргийн бус ажил хийж байгаад ажлын байрны осолд орж байсан гэж хариулав. Судалгаанд оролцсон 146 албан хаагчаас 143 оролцогч буюу 97.3 хувь нь заавал хийх эрүүл мэндийн үзлэгт орсон бол 151 оролцогчоос 148 оролцогч буюу 98 хувь аюулгүй ажиллагааны зааварчилгаа болон ажлын тусгай хувцас хэрэглэл авсан гэж хариулжээ.

4.6 Хугацаат цэргийн албан хаагчийн цэргийн бус ажлын шинж

Асуултад хариулсан 97 оролцогчоос 62 хүн буюу 64 хувь нь цэргийн бус ажилд томилохдоо тэдний саналыг харгалзан үздэг гэв. Оролцогчдын 30 хувь нь тэдний саналыг харгалздаггүй гэсэн бол 6 хувь нь заримдаа тэдний саналыг харгалзан томилдог гэжээ. Асуултад хариулсан 144 оролцогчоос 139 хүн буюу 96.5 хувь нь цэргийн бус шинжтэй ажил, үйлчилгээг гүйцэтгэхээс татгалзсан тохиолдолд ямар нэг заналхийлэл, шийтгэлд өртөж байгаагүй гэж хариулсан байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

5. Судалгааны дүн шинжилгээ, ОУХБ-ын зөвлөмж

5.1 Хугацаат цэргийн албан хаагчдыг цэргийн биш ажилд оролцуулж байгаа талаар тогтоогдсон баримтууд

Монгол Улсын одоогийн хууль тогтоомж, эрх зүйн орчны хүрээнд заавал хаах цэргийн албанд татагдсан хүнээр цэвэр цэргийн шинжгүй ажил буюу цэвэр цэргийн зориулалтаар гүйцэтгэхээргүй ажил, хөдөлмөр хийлгэх боломжтой байна. 339, 340 дүгээр цэргийн ангид хийсэн судалгаагаар бодит байдалд хугацаат цэргийн албан хаагчдаар цэргийн бус ажлыг төр, хувийн хэвшлийн байгууллагын ашиг сонирхлын дагуу гүйцэтгүүлдэг болох нь харагдлаа. Энэ байдлаас үүдэн ОУХБ-ын 29, 105 дугаар конвенцийн хэрэгжилттэй холбоотой асуулт гарч байна.

Судалгааны үр дүнгээс үзвэл судалгаанд оролцсон хугацаат цэргийн албан хаагчдын олонх нь цэргийн шинжгүй ажил сайн дурын үндсэнд гүйцэтгэдэг ажээ. Тэдний ихэнх хувь нь тийм ажил хийснийхээ төлөө цалин хөлс авдаг бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн наад захын нөхцөлд ажилладаг байна. Гэвч энэ нөхцөл нь 29 дүгээр конвенцоор зөвшөөрсөн хугацаат цэргийн албан хаагчид цэргийн биш ажил эрхэлж болох нөхцөлтэй нийцэхгүй байна. Тэрхүү ажлыг мөн л цэргийн албаны үүргийн дагуу гүйцэтгэж байх тул 29 дүгээр конвенцоор хориглосон албадан хөдөлмөрийн тодорхойлолтод хамаарна.

ОУХБ-ын Шинжээчдийн Хороо заавал хаах албаны үүргийн хүрээнд цэргийн албаны шаардлага болон цэргийн бус ажил үйлчилгээний хоорондох сонголт нь сайн дурын ажил, заавал хийх ажил хоёрын хоорондох сонголт биш харин заавал хийх хоёр ажил үйлчилгээний хооронд хийх сонголт мөн гэж дүгнэсэн юм.¹⁴ Цэргийн биш ажил, хөдөлмөр нь цэргийн мэргэжлийн бэлтгэл, сургуулилтанд чиглэж байвал хугацаат цэргийн албан хаагчаар тийм ажил хийлгэхийг 29 дүгээр конвенцод

¹⁴ Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ). 2007 он. Женев хотноо 2007 онд болсон Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагын 96 дугаар хуралдаан, III тайлан (1В хэсэг) Албадан хөдөлмөрийг устгах нь, Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29 дүгээр конвенц, Албадан хөдөлмөрийг устгах тухай 1957 оны 105 дугаар Конвенцтой холбоотой Ерөнхий судалгаа. 45 дугаар догол мөр.

зөвшөөрдөг болно.¹⁵ Энэхүү судалгааны хүрээнд цуглуулсан хугацаат цэргийн албан хаагчдаар хийлгэх мэргэжлийн бэлтгэл, сургуулилтын талаарх баримт нотолгоо нь барилга-инженерийн цэргийн 339, 340 дүгээр ангид дээрх шаардлагыг хангасан гэж дүгнэж болохоор дэлгэрэнгүй байж чадаагүй юм.

5.2 Хугацаат цэргийн албан хаагчдыг эдийн засгийн бүтээн байгуулалтад оролцуулахтай холбоотой баримт бичиг

Монгол Улсын Батлах хамгаалах бодлогын хүрээнд 2012-2016 оны Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Цэргийн алба хаагчдыг шинэ бүтээн байгуулалтад оролцуулах арга хэмжээ авах” зорилт тусгагдсан байна.” Монгол Улсын Засгийн газар 2013 онд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор цэргийн алба хаагчдыг бүтээн байгуулалтын ажилд оролцуулахын тулд “Монгол цэрэг бүтээн байгуулалтад” хөтөлбөрийг баталсан байна. Эдгээр бодлого зохицуулалтаар зэвсэгт хүчний байнгын бүрэлдэхүүн болон хугацаат цэргийн албан хаагчдыг цэргийн бус үйл ажиллагаанд татан оролцуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. Энэ судалгааны үр дүнгээс үзвэл хугацаат цэргийн албан хаагчдыг бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрийн хүрээнд цэргийн бус ажил гүйцэтгүүлдэг байна. Энэ баримт нотолгооноос үүдэн эдийн засгийн бүтээн байгуулалтын зорилгоор албан хөдөлмөрт дайчлан хэрэглэхийг хориглосон 105 дугаар конвенцийн заалтын хэрэгжилтийг хангаж чадаж байгаа эсэх талаар асуулт үүсгэж байна.

5.3 ОУХБ-ын зөвлөмж

1. Хууль тогтоомж, эрх зүйн орчинд өөрчлөлт оруулж заавал хаах цэргийн алба хааж буй хүмүүсийг мэргэжлийн арга, техник эзэмших сургалтын хүрээнээс буюу нарийвчлан тодорхойлсон онц байдал үүссэн нөхцөл байдлаас гадуур цэргийн бус ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй байх баталгааг хангах.

¹⁵ ОУХБ. 1979 он. Женев хотноо 1979 онд болсон Олон Улсын Хөдөлмөрийн Бага Хурал 65 дугаар хуралдаан. III хуралдаан (4В хэсэг), Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29 дүгээр конвенц, Албадан хөдөлмөрийг устгах тухай 1957 оны 105 дугаар Конвенцтой холбоотой Ерөнхий судалгаа, 29 дүгээр догол мөр.

2. Эрх зүйн орчин болон бодит практикт хөдөлмөр эрхлэх, бүтээн байгуулалтын хөтөлбөрт хамрагдах оролцоог сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх. Заавал хаах цэргийн алба хааж буй хүмүүсийг эдийн засгийн бүтээн байгуулалтын зорилгоор ашиглахаас татгалзах.
3. Заавал хаах цэргийн албаны хугацааг үндэсний батлан хамгаалах бодит шаардлагад нийцүүлэх. Бодлогын бусад зорилтыг (жишээ нь ажилгүйдлийг бууруулах, мэргэжлийн ур чадвар олгох зэрэг) иргэдийг албан үүрэгт дайчилгаагаар гэхээсээ хөдөлмөрийн зах зээлийн зорилтот бодлогоор шийдвэрлэж байх.

6. ХЭҮК–ын зөвлөмж, судалгааны үр дүн

6.1 ХЭҮК–ын зөвлөмж

Улсын Их Хуралд:

- Зэвсэгт хүчний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт “зэвсэгт хүчний бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр цэргийн зарим анги, байгууллагыг аж ахуй, бүтээн байгуулалтын ажилд оролцуулж болно.” гэж заасан нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний заалттай нийцэхгүй байгаа тул өөрчлөлт оруулах.

Монгол Улсын Ерөнхийлөгчид:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 153 дугаар зарлигийн хавсралтаар батлагдсан “Цэргийн анги, байгууллагыг аж ахуйн ажилд оролцуулах журам”-ын 2 дугаар зүйлд “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд чухал ач холбогдол бүхий төсөл хэрэгжүүлж буй төрийн болон хувийн аж ахуйн байгууллагаас цэргийн зарим анги, байгууллагыг гэрээгээр ангийн байрлалаас гадна ажиллуулахыг цэргийн анги, байгууллагыг аж ахуйн ажилд оролцуулах гэнэ.” гэж заасан нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний заалтад нийцэхгүй байна. Иймд дээрх журмын 2 дугаар зүйлийг ОУХБ-ын 29, 105 дугаар конвенцид нийцүүлэх ажлыг цаг алдалгүй хийж хэрэгжүүлэх нь зүйтэй.

Батлан хамгаалах яам болон Зэвсэгт хүчний жанжин штабт:

- Зэвсэгт хүчний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.8-д зэвсэгт хүчний анги, байгууллагыг аж ахуй, бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журмыг тогтоох бүрэн эрхийг зөвхөн Монгол Улсын Ерөнхийлөгчид олгосон бөгөөд хуулиар Зэвсэгт хүчний жанжин штабын даргын бүрэн эрхэд хамаарахгүй асуудлаар гаргасан 2010 оны 512 дугаар тушаалыг хүчингүй болгох.

6.2 Уулзалт, хэлэлцүүлэг

Судалгаагаар тогтоосон нөхцөл байдлыг ХЭҮК-оос 2013 оны 10 дугаар сард зохион байгуулж Батлан хамгаалах яамны төлөөллийг оролцуулан хурлаар эхний байдлаар хэлэлцэж, баталгаажуулсан юм.

Хурлын үеэр ХЭҮК барилга инженерийн 339, 340 дүгээр ангиудаас авсан санал асуулгын үр дүнг танилцуулав. Хуралд оролцогчид Монгол Улс дахь хугацаат цэргийн албанд хэвшсэн одоогийн нөхцөл байдал, олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх арга замыг голлон анхаарч ярилцлаа.

Хугацаат цэргийн албан хаагчдыг цэргийн бус хөдөлмөрт ашигладаг практик хугацаат цэргийн албан хаагч ямар ч ажил хийдэг байхыг шаарддаг байсан социалист дэглэмээс үүдэлтэй болохыг ХЭҮК-ын дарга онцолсон юм.

Зэвсэгт хүчний жанжин штабын дарга барилга-инженерийн зориулалттай цэргийн ангиудыг үндэсний аюулгүй байдлыг хангах, барилга-инженерийн тусгай ур чадвар олгох, мөн тодорхой түвшинд үндэсний хэмжээний сэргээн босголтод хувь нэмэр оруулах зорилгоор байгуулсан болохыг тэмдэглэв.

ХЭҮК-ын явуулсан судалгаагаар тогтоосон нөхцөл байдалд үндэслэн хуралд оролцогчид хугацаат цэргийн албан хаагчдыг хувь хүн, хувийн хэвшлийн байгууллагатай гэрээ байгуулан цэргийн бус ажилд оролцуулах зэрэг асуудлуудыг шийдвэрлэхийн тулд арга хэмжээ авах шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрлөө.

Батлан хамгаалах яамны төлөөлөл ХЭҮК-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хэсэг гаргахаа мэдэгдэв. Уг ажлыг хэсэг нь эрх зүйн орчныг боловсронгуй болгож, олон улсын гэрээ конвенцтой нийцүүлэхэд чиглэсэн арга хэмжээг санал болгох юм. Зэвсэгт хүчний жанжин штабын төлөөлөл мөн ХЭҮК-ын тавьсан асуудлуудыг шийдвэрлэх тодорхой арга хэмжээ авах талаар санал нийллээ.

2015 оны 12 дугаар сарын байдлаар Монгол Улсад ХЭҮК-ын зөвлөмжид туссан албадан хөдөлмөрийг зохицуулсан холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд зохих нэмэлт өөрчлөлт оруулах буюу тэдгээрийг шинэчлэн найруулах ажил хийгээгүй байв.

Ашигласан материал

Монгол Улсын Үндсэн хууль (1992 он).

Монгол Улсын Засгийн газар. 2012 он. *Засгийн Газрын мөрийн хөтөлбөр* (2012-2016 он). <http://www.legalinfo.mn/annex/details/5732?lawid=8859> [2015 оны 5 дугаар сарын 20].

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ). 1930 он. *Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29 дүгээр конвенц* (Женев хот).

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ). 1957 он. *Албадан хөдөлмөрийг устгах тухай 1957 оны 105 дугаар конвенц* (Женев хот).

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ). 2007 он. Женев хотноо 2007 онд болсон Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 96 дугаар хуралдаан, III тайлан (1В хэсэг) *Албадан хөдөлмөрийг устгах нь, Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29 дүгээр конвенц, Албадан хөдөлмөрийг устгах тухай 1957 оны 105 дугаар конвенцтой холбоотой Ерөнхий судалгаа*.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ). 2009, 2011, 2013 он. *Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29 дүгээр конвенцийг Монгол Улсын хэрэглэж байгаа байдалтай холбоотой асуудлаар шууд хүсэлт*. <http://www.ilo.org/normlex> [2015 оны 5 дугаар сарын 17].

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ). 2012. Женев хотноо 2012 онд болсон Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагын 101 дүгээр хуралдаан, III тайлан (1В хэсэг) *Шударга даяаршлын төлөө нийгмийн шударга ёсны талаарх ОУХБ-ын Тунхаглалаас үүдэлтэй ажлын байран дээрх эрхүүдтэй холбоотой суурь конвенцуудын талаарх Ерөнхий судалгаа*.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль (1999 он).

Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль (1992 он).

Монгол Улсын Зэвсэгт Хүчний тухай хууль (2002 он).

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс. 2012 он. *Монгол Улс дахь хүний эрхийн эрх чөлөөний байдлын талаарх 11 дэх илтгэл* (Улаанбаатар хот).

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс. 2014 он. *Монгол Улс дахь хүний эрхийн эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл* (Улаанбаатар хот).

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо. 2010 он. *2010 оны хүн ам, орон сууцны тооллого*. <http://en.nso.mn/content/109> [2015 оны 5 дугаар сарын 18].

Дэлхийн Банк. 2013 он. *‘Зэвсэгт хүчний албан хаагчид, нийт Дэлхийн Банкны Нээлттэй Баримт Мэдээлэлд*. <http://data.worldbank.org/indicator/MS.MIL.TOTL.P1> [2015 оны 5 дугаар сарын 19].

Хавсралт I. Үр дүнгийн хурал: Оролцогчдын нэрс

Судалгаагаар тогтоосон нөхцөл байдлыг ХЭҮК-оос 2013 оны 10 дугаар сард зохион байгуулж Батлан хамгаалах яамны төлөөллийг оролцуулсан хурлаар эхний байдлаар хэлэлцэж, баталгаажуулав.

Оролцогчдын нэрс:

- Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Бямбадорж
- Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Н.Ганбаяр
- Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албаны дарга А.Дашдэлэг
- Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол, хяналт шалгалт, бодлогын дүн шинжилгээний хэлтсийн дарга Г.Агар-эрдэнэ
- Хүний эрхийн Үндэсний Комиссын Ахлах референт Б.Батаа
- Монгол Улсын Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, хошууч генерал З.Борбаатар
- Монгол Улсын Батлан хамгаалах яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, хурандаа Д.Мөнх-Очир
- Монгол Улсын Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө орууллагын газрын дарга, хурандаа Н.Батсүх
- Монгол Улсын Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, дэслэгч генерал Ц.Бямбажав
- Монгол Улсын Зэвсэгт хүчний жанжин штабын орлогч дарга, хошууч генерал Б.Баярмагнай
- Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын үндэсний зохицуулагч П.Болормаа

ОИН.МН
СУДАЛГААНЫ САН